

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН НЭРЭМЖИТ УРАЛДААНЫ
ШИЛДГҮҮДИЙГ ШАЛГАРУУЛЖ,
ШАГНАЛ ГАРДУУЛЛАА

1

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ
АКТЫН ЭМХЭТГЭЛИЙН 2024 ОНЫ 27, 28
ДАХЬ ДУГААР ХЭВЛЭГДЛЭЭ

3

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН ШҮҮХИЙН
АКАДЕМИТАЙ ХАМТРАН
“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОЛОН
МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА” СЭДЭВТ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ 2024 ОНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ
ӨДӨР ХУУЛЬЧДЫН ТАНХИМД
ЗОХИОН

5



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Баталсан хууль нь хүн
бүрт тэгш үйлчилдэг
төр л хатгийн
тогтвортой оршдог.

Аристотель

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ

www.nli.gov.mn

Цахим сонин

2024.11.30

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ УРАЛДААНЫ ШИЛДГҮҮДИЙГ ШАЛГАРУУЛЖ, ШАГНАЛ ГАРДУУЛЛАА

Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит эрдэм шинжилгээний “Шилдэг бүтээл”, “Оюутны шилдэг илтгэл”, “Грант олгох төсөл”-ийн уралдааны шилдгүүдэд шагнал гардуулах ёслолын ажиллагаа 2024.11.20-нд ХЗДХЯ-ны хурлын танхимд боллоо. Тус уралдааныг Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Дотоод хэргийн их сургууль хамтран дөрөв дэх жилдээ зохион байгуулж байна. Энэхүү ёслолын ажиллагаанд Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Дотоод хэргийн их сургуулийн ректор, доктор, профессор, бригадын генерал П.Батбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах болон ХЗДХЯ,



түүний харьяа агентлаг, байгууллагуудын удирдлагын төлөөлөл, эрдэмтэн, судлаач, сонсогч, оюутнууд оролцов. Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл шагнал гардуулах ёслолын ажиллагааны үеэр хэлэхдээ “Энэ жилийн уралдааны “Оюутны шилдэг илтгэл”, “Грант олгох төсөл”-ийн төрөлд ирүүлсэн илтгэл, төслийн тоо нэмэгдэж, бүтээлийн чанар, чансаа сайжирсан байгаагаас энэхүү уралдааны цар хүрээ өргөжиж, эрдэмтэн, судлаач, сонсогч, оюутны зорилго тавьж бэлтгэн оролцдог, мэдлэг, оюунаа сорьдог томоохон шалгаруулалт болжээ гэж дүгнэж болохоор байна. Энэхүү уралдаанд амжилттай оролцож шилдгээр шалгарч, шагнал, грантаа гардан авахаар ирсэн эрдэмтэн, судлаач, сонсогч, оюутан та бүхэнд баяр хүргэж, цаашдын эрдэм судлал, сурлага, хөдөлмөрт өндөр амжилт хүсэн ерөөе. Та бүхэн Монголын ирээдүй, хууль зүйн салбарын шилдэг мэргэжилтнүүд гэдгийг тодотгон хэлье” хэмээв. Тус уралдаанд “Шилдэг бүтээл”-ийн төрөлд 27 бүтээл, “Оюутны шилдэг илтгэл”-ийн төрөлд

ШИЛДЭГ БҮТЭЭЛ:

1-р байрт: МУ-ын гавьяат хуульч, Үндсэн хуулийн цэцийн ишүүн асан, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор, доктор, профессор Ш.Цогтоогийн “Монгол Улсын захиргааны эрх зүй: Ерөнхий, тусгай анги”

2-р байр: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрхзүйн тэнхимийн дэд профессор, доктор Б.Буянхишигийн “Иргэний процесс дахь нотолгооны эрх зүй”

3-р байр: Хуульч, өмгөөлөгч Б.Ганболдын “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар эрдэм шинжилгээний бүтээл”

Тусгай байр:

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ

Улсын бүртгэлийн дугаар 1197

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Эко Интернэйшл трейд тауэр барилгын 9 давхар,
Хууль зүйн үндэсний хүрээлэн.

11-315789

www.nli.gov.mn

Бэлтгэсэн: Б.Бат-Эрдэнэ

-ДХИС-ийн Гадаад хэлний институтын захирал, ктор, цагдаагийн дэд хурандаа Б.Лхагварагчаа, Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн профессор, доктор, цагдаагийн хурандаа Б.Цогтбаатар, Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, доктор, цагдаагийн хошууч Г.Болор-Эрдэнэ нарын “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг шалгах арга зүй”,

-ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн профессор, доктор, дэд хурандаа Ц.Ганчимэг, Эдийн



засаг, нөөц, ар талын тэнхимийн профессор, доктор, дэслэгч Б.Одгэрэл нарын “Ар талын хангалтын үндэс” бүтээл тус тус шалгарсан байна.

ШИЛДЭГ ИЛТГЭЛ:

1-р байр: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан Л.Хоролсүрэн “Монгол Улс дахь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль хэрэглээний асуудал ба эрүүгийн хэргийг нэгтгэх ажиллагааны зорилтыг хангах нь”

2-р байр: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан Э.Хишигсүрэн “Санхүүгийн зардал (зээлийн шимтгэл), түүнийг хэм хэмжээгээр зохицуулахад анхаарах нь”

3-р байр: Дотоод хэргийн их сургуулийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-ШШГАС-ийн 541 дүгээр дамжааны дэд түрүүч Б.Өсөхбаяр “Хоригдлын шашин шүтэх эс шүтэх эрхийн хэрэгжилт, анхаарах асуудал” илтгэл шалгарлаа.

Тусгай байр

-ДХИС-ийн ЭЗНУС-ийн 241 дүгээр дамжааны оюутан М.Энхням “Монгол Улс дахь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний өнөөгийн нөхцөл байдал, онол практикийн тулгамдаж буй асуудал”,

-МУИС-ийн Хууль зүйн сургуулийн IV түвшний оюутан М.Үүрийнтуяа “Эрүүгийн процесс ажиллагаанд хэргийн оролцогчид эвлэрэх, хууль зүйн боломжийг нэмэгдүүлэх тухай”,

-МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V түвшний оюутан Т.Эмүжин “Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн гомдлыг Үндсэн Хуулийн Цэц хянан шийдвэрлэх тухай асуудал” сэдэвт илтгэлээр тус тус шалгарлаа.

**ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛИЙН 2024 ОНЫ 29,
30, 31, 32, 33 ДАХЬ ДУГААР ХЭВЛЭГДЛЭЭ****ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, ШҮҮХИЙН АКАДЕМИТАЙ ХАМТРАН “АВЛИГАТАЙ
ТЭМЦЭХ БОЛОН МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА” СЭДЭВТ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР ХУУЛЬЧДЫН ТАНХИМД ЗОХИОН
БАЙГУУЛЛАА**

Тус хэлэлцүүлгийг АНУ-ын Калифорни мужийн дүүргийн шүүхийн шүүгч Роберт С.Хуи удирдан явуулав Хэлэлцүүлэгт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтнууд болон Шүүхийн академийн Эрүүгийн эрх зүйн секторын судлаачид, УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын судлаач туслахууд тус тус хамрагдлаа.



ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААНЫГ АМЖИЛТТАЙ
ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн хэлний зөвлөлийн анхдугаар хуралдааныг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгууллаа. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дэргэд хууль зүйн нэр томьёог шинжлэх ухааны үндэслэлтэй оноон тодорхойлох, жигдлэн хэвшүүлэх, нэр томьёотой холбогдсон асуудлаар зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Хууль зүйн хэлний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/75 дугаар тушаалаар зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг баталсан. Тус зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд зөвлөлийн анхдугаар хуралдаанд 11 гишүүн оролцож, зөвлөлийн даргыг нууц санал хураалтаар сонгох, хуралдааны дэгийн төсөл болон 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг тус тус хэлэлцлээ. Хууль зүйн хэлний зөвлөлийн даргаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах сонгогдож, зөвлөлийн үйл ажиллагааны тэмдгийг гардан авлаа.

ТӨСЛИЙН УУЛЗАЛТ-СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН
БАЙГУУЛЛАА

Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын хууль зүйн салбарын хууль зүй, мэдээллийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан /www.legalinfo.mn/-гийн цахим хуудаст хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал хүлээн авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, дэлгэрэнгүй тайлан, мэдээллийг гарган авах модуль хөгжүүлэлтийн ашиглалтын талаар сургалтыг “Хууль үндэсний хүрээлэн” болон “Интерактив” хамтран ХХК 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Уг сургалтад 23 байгууллагын 35 албан хаагчид хамрагдсан бөгөөд мэдээлэл оруулагч 7 байгууллагын албан хаагч, 16 яамны хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний

Актын төсөл оруулах чиг үүргийг хариуцах мэргэжилтнүүдэд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан /www.legalinfo.mn/–д цахим хуудаст хийгдсэн нэмэлт хөгжүүлэлтийн танилцуулга, түүнийг ашиглах аргачлалыг танилцуулсан сургалт-уулзалтыг Интерактив ХХК-ийн төслийн менежер О.Чингис-Од, ХЗҮХ-ийн ЦМОНХТөвийн дарга С.Билигсайхан нар удирдан явуулж, системийн сайжруулалтын талаар талууд санал солилцов.



“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛИЙН 2024 ОНЫ III УЛИРЛЫН №99 ДЭХ ДУГААР ХЭВЛЭГДЛЭЭ. “ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛИЙН 2024 ОНЫ АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ №101 ДЭХ ТУСГАЙ ДУГААРТ ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА. ТА БҮХЭН СЭТГҮҮЛД ТАВИГДАХ ШААРДЛАГЫН ДАГУУ LAWJOURNAL@LEGALINSTITUTE.MN ЦАХИМ ШУУДАНГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС САНААЧЛАН “АВЛИГЫГ МЭДЭЭЛЬ” АЯН ЗОХИОН БАЙГУУЛАЖ БАЙНА

Аяны зорилго: Тус аяны зорилго нь Иргэд олон нийтэд авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/-ийг танилцуулах болон авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хэрхэн мэдээлэх талаар мэдээлэл хүргэхэд оршино.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 2.1 дүгээр зүйлийн 13 дахь хэсэг Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, таниулах ажлыг үр дүнтэй, хүртээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах” чиг үүргийн хүрээнд “Авлигын эсрэг багц хууль”-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний судалгааны тайланг үндэслэн иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэхээр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2024 оны 11 дүгээр сарын 27-ний өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хооронд зохион байгуулахаар төлөвлөсөн.



МОНГОЛ УЛСЫН “ШИНЖЛЭХ УХААНЫ АЖИЛТНЫ ӨДӨР”-ИЙГ ТОХИОЛДУУЛАН ЖИЛ БҮР
ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГҮҮДИЙН ДУНДАХ СПОРТЫН
5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙГ 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 21, 22-НЫ ӨДРҮҮДЭД УС ЦАГ УУР, ОРЧНЫ
СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН ЗОХИОН

Уг тэмцээнд эрдэм шинжилгээний 9 хүрээлэнгийн нийт 200 гаруй албан хаагч, хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс багийн дүнгээр Нийслэлийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн баг тамирчид тэргүүлээ Хууль зүйн Үндэсний Хүрээлэн албан хаагчид жил бүр тогтмол амжилттай оролцдог бөгөөд Шатрын эрэгтэй төрөлд Харуул С.Эрдэнэпүрэв хүрэл медаль авлаа.





1800-1202

ЦАГИЙН ХУВААРЬ

08:30-17:30

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН
ЛАВЛАХ ДУГААРТ 08:30-17:30 ЦАГИЙН
ХООРОНД ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР
ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ